



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 11 сарын 12 өдөр

Дугаар 3/58

Чингис хот

Б.Дархантөрийг ажилд томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Хөдөлмөрийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2, 23.2.2, 24 дүгээр зүйлийн 24.1, Засгийн газрын 2019 оны 9 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журам"-ын 2.3-т заасныг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Өндөржүүлсэн бэлэн байдал зарлагдсантай холбогдуулан Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 01 дүгээр зөвлөмжийн дагуу ажлын зайлшгүй шаардлагаар хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгээ Авлигатай тэмцэх газарт хянуулж, ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал тогтоогдоогүй Батжаргалын Дархантөрийг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын албан тушаалд 2020 оны 11 дүгээр сарын 13-ны өдрөөс эхлэн хорио цээрийн дэглэм цуцлагдах хүртэл хугацаанд хөдөлмөрийн гэрээгээр ажиллуулсугай.

2. Ажил хүлээнцүүлэх ажлын хэсгийг досрх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн

ахлагч: Э.Мөнх-Эрдэнэ

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга

Гишүүд: Ц.Бат-Эрдэнэ

Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн Хөрөнгө оруулалт, өмчийн бодлого хариуцсан мэргэжилтэн

Л.Түмэнжаргал

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын нягтлан бодогч


3. Б.Дархантөрийн цалинг хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу 1088657 /нэг сая наян найман мянга зургаан зуун тавин долоон/ төгрөгөөр тооцож, бусад зохих нэмэгдлийг олгохыг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын нягтлан бодогч /Л.Түмэнжаргал/-д зөвшөөрсүгэй.

4. Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын албан тушаалын тодорхойлолтод заагдсан чиг үүрэг болон хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Б.Дархантөрд үүрэг болгосугай.

5. Б.Дархантөрд томилогдсоноос хойш 30 хоногийн дотор хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгээ аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэс /Ж.Гантулга/-т гаргаж өгөх үүрэгтэйг сануулсугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.ИДЭРБАТ



231010945